



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар A/345

Улаанбаатар хот

**Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ  
үзүүлэх "Орон нутгийн мэргэжлийн хамтарсан  
баг" байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2024 оны А/76, А/515, 2025 оны А/28, А/27 дугаар тушаал, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Чингэлтэй ахмадууд-2028" арга хэмжээ батлах тухай 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн ахмад настуудын бие бялдар, танин мэдэхүй, сэтгэл зүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлж, хэрэгцээ болон эрсдэлийн зэргийг үнэлэн мэргэжлийн олон талт цогц тусламж үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий "Орон нутгийн мэргэжлийн хамтарсан баг"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

|                          |            |                                                                  |
|--------------------------|------------|------------------------------------------------------------------|
| Ахлагч:                  | Л.Баярмаа  | Засаг даргын Тамгын газрын<br>Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга   |
| Гишүүд:                  | А.Сэрээтэр | Дүүргийн Хөдөлмөр, халамжийн<br>үйлчилгээний хэлтсийн дарга      |
|                          | П.Төвсанаа | Дүүргийн Ахмадын хорооны дарга                                   |
|                          | Х.Азбаяр   | Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил,<br>хамгааллын хэлтсийн дарга |
| Нарийн бичгийн<br>дарга: | Х.Ганцэцэг | Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн дарга                                 |

2. "Орон нутгийн мэргэжлийн хамтарсан баг"-ийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хэрэгжилтийг тооцон, үр дүнг танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Л.Баярмаа)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ